



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ДУНДГОВЬ АЙМГИЙН  
АУДИТЫН ГАЗАР  
АКТ

48090 Дундговь аймаг,  
Сайнцагаан сум, Нарлаг баг  
Утас: 70-59-24-39, 70-59-22-08, 70-59-32-08  
E-mail: dundgovi@audit.gov.mn

САЙНЦАГААН СУМЫН  
МАТЕМАТИКИЙН ГҮНЗГИЙРҮҮЛСЭН  
СУРГАЛТТАЙ ДӨРӨВДҮГЭЭР СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ Ц.ОДОНЧИМЭГ ТАНАА

2017.02.24 № 01/21 ДУА-ДО/7/93/СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд аймгийн Аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Сайнцагаан сумын Математикийн гүнзгийрүүлсэн сургалттай дөрөвдүгээр сургуулийн 2016 оны санхүүгийн тайланд аudit хийх явцад ажилтан албан хаагчдад түлээ, нүүрсний хөнгөлөлт олгоходо нийгмийн даатгалын шимтгэл суутгаж тооцсон дунгээс хувь хүний орлогын албан татварыг тооцож **54,000.00 /Тавин дөрвөн мянган/** төгрөгийг илүү олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйл буюу шууд бус орлого 15.1.2-т /орон сууцны ашиглалтын зардлын төлбөр, бэлнээр олгосон байрны хөлс, тулиний зардал/, 22 дугаар зүйлийн 22.1.4.-т /шууд бус орлогод ногдуулах албан татварыг тухайн орлогын дүнгээр./ 23 дугаар зүйлийн 23.1-т /Энэ хуулийн 17-19 дүгээр зүйл, 20.1.2-20.1.5, 22.1.4-т зааснаар тодорхойлсон орлогын жилийн дунд 10 хувиар тооцож албан татвар ногдуулна/ заасныг тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжсээч, аудитор, шинжсээч нь аудитын явцад илэрсэн төлборийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлборийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.3-т /Бусдад өгөх төлбөр тооцоог зөрүүтэй тооцоолжс олгосон/ заасан заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

- Илүү тооцож олгосон **54,000.00 /Тавин дөрвөн мянган/** төгрөгийг холбогдох албан тушаалтнаас суутган тооцож, Татварын хэлтсийн **100080000901** тоот дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2017 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор Аудитын газарт ирүүлэхийг Сайнцагаан сумын Математикийн гүнзгийрүүлсэн сургалттай дөрөвдүгээр сургуулийн захирал /Ц.Одончимэг/, нягтлан бодогч /И.Тогтоол/ нарт хариуцуулав.

## АКТЫГ

ТОГТООСОН<sup>1</sup>:

АУДИТОР  Т.ОЮУН-ЭРДЭНЭ

ЗӨВШӨӨРСӨН:

Сайнцагаан сумын Математикийн  
гүнзгийрүүлсэн сургалттай сургуулийн:

ЗАХИРАЛ

Ц.ОДОНЧИМЭГ

НЯГТЛАН БОДОГЧ 

И.ТОГТООЛ

---

<sup>1</sup> Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.